



Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС,
АГЕНТЛАГУУДЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ.ЗОРИЛГО

ХОЁР.ҮНДЭСЛЭЛ АРГА ЗҮЙ

ГУРАВ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

3.2 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

3.3 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн агентлагт хамааралтай заалтын хэрэгжилт

4.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

4.3 Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

5.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

5.3 Хөндлөнгийн үнэлгээ

ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

6.1 Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний агентлагийн даргын хүлээх үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил

ДОЛОО.ДҮГНЭЛТ

НАЙМ ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС,
АГЕНТЛАГУУДЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 03 дүгээр сарын 20

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж, цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, байгууллагын нээлттэй ил тод байдлыг үнэлэхдээ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлав.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүү төрийн сангийн хэлтсийн өгсөн дүнг шууд хэрэглэсэн.


Хөндлөнгийн үнэлгээг орон нутгаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож буй байдал, хугацаатай тайлан мэдээний чанар, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэргийг үндэслэн дээд шатны удирдах албан тушаалтнуудаас санал асуулгын хуудсаар авах ажлыг Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс зохион байгуулж үнэлгээнд оруулан тооцов.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний агентлагийн даргын хүлээх үүргийн биелэлтийн үнэлгээг ажлын хэсэг газар дээр нь очин итгэл сонсон үнэлгээг өгсөн.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг агентлаг тус бүрд хэрэгжиж байгаа нийтлэг болон тусгай заалтын дунджаар хэрэгжилтийг тооцсон. Мөн баримт нотолгоонд үндэслэн тодорхой тайлагнаж бодит үр дүнг нэмэгдүүлсэн хэрэгжилтийн явцыг харгалзан үнэлгээг өгсөн.



Дүгнэлт, зөвлөмжийн талаар: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тусгай болон нийтлэг хэрэгжиж байгаа заалтын хэрэгжилтийн шалгуурыг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээ үнэлгээг хийхэд үнэлгээний дундаж 90.7 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 13.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид хууль, тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг бүрэн хяналтад авч сар бүр тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулан тайланг, нотлох баримтын хамт тогтоосон хугацаанд чанартай тайлагнаж хэвших шаардлагатай.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс агентлаг тус бүрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үнэлгээг өгсөн.




Дүгнэлт, зөвлөмжийн талаар: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний агентлагт хамааралтай заалтуудын хэрэгжилтийн дундаж 93,8 хувьтай байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний үйл явцыг биш, гүйцэтгэлийн үр дүнг тоо баримт, нотолгоотой тайлагнах хэрэгтэй.

Цаашид тухайн хөтөлбөрийн төлөвлөсөн арга хэмжээ нь хүрэх түвшиндээ хүрсэн эсэх, хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрснийг тайлбарлаж нотолсон хэрэгжилтийг тооцож үнэлэхийг анхаарна уу. Мөн суурь судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх шаардлагатай байна.

Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг үнэлэхдээ 2022-2024 оны эдийн засгийн үзүүлэлтийн төлөвлөлтөд үндэслэн ирүүлсэн тайлангаас гадна аймгийн статистик мэдээ, Үндэсний статистикийн хорооны Статистик мэдээллийн нэгдсэн сан (1212.mn), байгууллагуудын салбарын статистик мэдээлэлтэй тулган үзэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйг баримтлан үнэлгээг өгөв.



Дүгнэлт, зөвлөмжийн талаар: Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг шинэчлэн баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу гаргуулж статистик мэдээтэй тулгалт хийж дүгнэхэд үнэлгээний дундаж 88.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь эдийн засгийн үзүүлэлтийг 2022-2024 он хүртэлх төлөвлөлтийг хийж үзүүлэлтүүд өөрчлөгдсөнтэй холбоотой гэж үзэж байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээ 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж байгаа Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Статистикийн хэлтэс, Татварын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Биеийн тамир спортын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газар зэрэг агентлагууд байна.

Хамгийн муу үнэлгээтэй буюу 80 хувиас доош үнэлэгдсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Соёл урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс зэрэг агентлагууд эдийн засгийн үзүүлэлтийн биелэлтээ нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулах нь зүйтэй байна.

Цаашид агентлаг бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг авч суурь түвшинтэй уялдуулж, зорилтот түвшнийг бодитой төлөвлөх, хэрэгжилтийн бодит үр дүнг сайжруулах шаардлагатай байна.


Аймгийн статистикт өгч байгаа тоон мэдээллийг салбарын тоон мэдээлэлтэй зөрүүтэй байгаа нь гарч буй тоон мэдээллийг хянадаггүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Иймд байгууллагын удирдлагууд мэргэжилтэн албан хаагчдын судалгаа, тайлан мэдээнд хяналт тавьж бодит үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөж байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээг гаргахдаа тухайн агентлагт хамааралтай заалтын дундаж үнэлгээгээр гаргасан.



Дүгнэлт зөвлөмжийн талаар: Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний дундаж 94.2 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж өмнөх онтой харьцуулахад 1 хувиар ахисан байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10а хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг


бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Хэрэгжилт удаашралтай байгаа болон тасарч болзошгүй арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж удирдлагуудыг мэдээллээр хангах байх.

Тайлан мэдээний чанарт анхаарч оны эхнээс өөрийн агентлагт хамааралтай арга хэмжээ тус бүр дээр зарцуулсан хөрөнгийн хэмжээг зайлшгүй тайлагнаж байхаас гадна заалт тус бүрийн нотлох баримтыг оны эхнээс цуглуулж хагас, бүтэн жилээр нотлох баримттайгаар тайлан мэдээний хуваарийн дагуу тайлагнаж байх шаардлагатай.

Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж баталгаажсан үнэлгээг шууд хэрэглэсэн.




Дүгнэлт зөвлөмжийн талаар: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,7 хувьтай үнэлэгдсэн бөгөөд урд онтой харьцуулахад 1,7 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хянаж бодит үр дүнг тооцож ирүүлж байх шаардлагатай.

Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар улирал бүр байгууллага дээрээ хяналт шинжилгээ хийж, цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авч байхыг зөвлөж байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

Байгууллагын дотоод үйл ажиллагааны үзүүлэлтийн биелэлтийг жилийн эцсийн тайлангуудад үндэслэн холбогдох хэлтсүүд үнэлгээг өгч үнэлгээний нэгдсэн дүнг гаргасан.



Дүгнэлт, зөвлөмжийн талаар: 2023 оны хувьд зөвлөмжийн хэрэгжилт, СӨГ-ийн шийдвэрлэлт, Цахим шилжилт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Байгууллагын албан хаагчдыг хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд тодорхой төсөв баталж зарцуулсан байдал, Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байдал зэрэг 12 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хариуцсан хэлтэс бүр үнэлгээг өгч нэгтгэн дүгнэхэд үнэлгээний дундаж 79,9 хувьтай байна.

Энэ нь өнгөрсөн оноос 9,1 %-иар буурсан үзүүлэлттэй байна.


Цаашид өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар санал санаачилга гарган ажиллах шаардлагатай байна. Өмнө нь өгсөн зөвлөмжийг дахин давтан гаргахгүй байх талаар удирдлага арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг агентлагийн удирдлагууд анхаарах хэрэгтэй.

Байгууллагын дотоод үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн ажилтай уялдуулан өөрчилж боловсруулдаг тул байгууллагын дотоод үйл ажиллагааг тасралтгүй жигд хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөж байна.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг 46 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтын төрийн байгууллагууд хэсэгт агентлаг бүрийн байршуулсан мэдээлэлд үндэслэн төрийн захиргааны удирдлагын хэлтсээс үнэлгээг өгсөн.




Дүгнэлт зөвлөмжийн талаар: Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 9 дүгээр хавсралтын дагуу 46 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс үзэж үнэлгээний дүнг гаргахад үнэлгээний дундаж 71,9 хувьтай байгаа нь өмнөх оноос 15,5 хувиар өссөн хэдий ч төдийлөн хангалттай бус байна.

Иймд Төрийн захиргааны удирдлагын хэлтэс болон агентлагууд онцгойлон анхаарч, дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу тухай бүр мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд тогтмол оруулж хэвших шаардлагатай байна.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс өгсөн үнэлгээг шууд хэрэглэлээ.




Дүгнэлт зөвлөмжийн талаар: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн дундаж 98,7 хувьтай байгаа нь өмнөх оноос 2,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шилэн дансанд мэдээллийг 2022 онд 5 агентлаг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байсан бол энэ онд 16 агентлаг 100 хувь хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна. Иймд мэдээллийг хуулийн хугацаанд 100 хувь байршуулахыг зөвлөж байна.


Хөндлөнгийн үнэлгээ

Хөндлөнгийн үнэлгээг орон нутгаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож буй байдал, хугацаатай тайлан мэдээг ирүүлсэн байдал, тайлангийн чанар, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэргийг харгалзан дээд шатны удирдах албан тушаалтнуудаас санал асуулгыг хуудсаар авч нэгтгэн үнэлгээг гаргасан. Үнэлгээний дундаж 81,1 хувьтай байна.



ЗУРГАА. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ, ОНЦЛОХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ:

Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажлын үр дүнг тухайн ажлын хэсэг байгууллага дээр нь очиж илтгэл сонсон, байгууллагын үйл ажиллагаатай танилцан үнэлгээг өгч ажиллав.



Дүгнэлт зөвлөмжийн талаар: Агентлагуудын үнэлгээний дундаж 81,1 хувьтай байна.

Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажлын үр дүнг тооцохдоо тухайн жилд хийсэн онцлох ажлууд, илтгэл бэлтгэсэн байдал, илтгэх ур чадвар гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгч ажлын хэсгийн гишүүдийн дундаж үнэлгээгээр үнэлгээний дүнг гарган тооцов.

Цаашид хийж, хэрэгжүүлсэн ажлаа бүрэн тайлагнах, мэдээллээ ойлгомжтой байдлаар үр дүн талаас нь танилцуулах, бусдад туршлага болохуйц, олон нийт рүү чиглэсэн шинэ санал санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

ДОЛОО. НЭГДСЭН ДҮГНЭЛТ


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг

даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу удирдамж, аргачлал боловсруулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгтгэн дүгнэв.

2023 оны үйл ажиллагааны үр дүнг 10 үзүүлэлтээр үнэлж, дүгнэн үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын 2024 оны А/88 дугаар захирамжаар баталгаажуулав.

Засаг аргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 90,7 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 88,6 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 84,1 хувь, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээний дундаж 81,1 хувь, үнэлгээний ерөнхий дундаж 86,1 хувьтай байна.

Үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээний дундаж 86,1 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3,1 хувиар өссөн байна.



Үнэлгээний дүнгээс харахад БОАЖГ, ГХБХБГ, УЦУОШТ, ХХААГ, МЭГ, СХ, ТХ, НДХ, БТСГ, ЭМГ, СУГ, БШУГ, ЭМНДХ, УБХ, ЦГ, ШШГГ, ШШХ, ОБГ гэсэн 18 агентлагийн үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос өссөн ба бусад агентлагийн үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос буурсан байна.

2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр Цагдаагийн газар тэргүүн байр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Дэд байр, Татварын газар Гутгаар байр

эзэлсэн бол Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн газар зэрэг 3 агентлаг дутагдалтай үнэлэгдсэн байна.

Үйл ажиллагааны үзүүлэлтүүдээс мэдээллийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ 71,9 хувь, байгууллагын дотоод үйл ажиллагааны үнэлгээ 79,9 хувьтай байгаа тул агентлагууд онцгойлон анхаарч үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг ахиулж ажиллах нь зүйтэй.

ТАВ. НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үр дүнг хагас бүтэн жилээр тооцож, хэрэгжилтийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлэх.
2. Салбарын тоон үзүүлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн суурь судалгаанд ашиглах мэдээллийн сан бүрдүүлэн, цахим хуудсанд байршуулах
3. Цахим хуудасны орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх
4. Байгууллагын цахим хуудаст мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн байршуулж, ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх
5. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр улирал бүр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг хавсралт хүснэгтийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж хэрэгжилт, үр дүнг тооцон 2024 оны 06 сарын 25, 11 сарын 15-ны дотор ХШҮХ-т ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Хавсралт 1

**2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хамтран хэрэгжүүлэгч
1	2	3	4	5	6	7	8
1							
2							
3							

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН
.....ДАРГА.....
ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
.....МЭРГЭЖИЛТЭН.....

Хавсралт 2

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Эхний хагас	Жилийн эцэс		
1	2	3	4	5		6	7	8
1								
2								
3								
Хэрэгжилтийн дундаж хувь								

ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАСАН
.....ДАРГА.....
ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН
.....МЭРГЭЖИЛТЭН.....